# “”ОЮУ ТОЛГОЙ ХХК-ийн УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО””-НЫ
# 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**2025 оны 12 сарын 30**

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ БҮТЭЦ

Төлөөлөн удирдах зөвлөл (17 тойргийн тэргүүлэгч гишүүд)

ҮЭ-ийн Хорооны дарга

Хяналтын зөвлөл-5 гишүүн

ҮЭ-ийн Хорооны үйл ажиллагааны менежер

ҮЭ-ийн Хорооны санхүүгийн ажилтан

Нийт 24 хүний бүрэлдэхүүнтэй тус ҮЭ-ийн Хорооны өдөр тутмын үйл ажиллагаа явагдаж байна.

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

***Нийт 2000 гишүүнтэй, 17-н тойрогтой, Хяналтын хороо, Ажлын алба гэсэн зохион байгуулалтаар өдөр тутмын үйл ажиллагааг явуулж байна. Санхүү, нягтлан бодох үйл ажиллагааг ‘’ Мэжик консалтинг аудит’’ ХХК, Хөдөлмөрийн харилцаа бусад хуулийн холбогдох асуудлаар ‘’ Жаститиа админ лекс Консалтинг ‘’ ХХК зөвлөн туслах гэрээний дагуу хариуцан ажилладаг.***


3-р тойрог


Х/х гишүүн


11-р тойрог


12-р тойрог


14-р тойрог


2-р тойрог


Х/х гишүүн


7-р тойрог


8-р тойрог


9-р тойрог


5-р тойрог


ҮЭХ Дарга


6-р тойрог


10-р тойрог


4-р тойрог


Х/х гишүүн


1-р тойрог


15-р тойрог


16-р тойрог


13-р тойрог


ҮЭХ Менежер


17-р тойрог

# ҮЭ-ИЙН ХОРОО БҮХ АСУУДАЛД ХАМТЫН ШИЙДВЭР ГАРГАДАГ



- ҮЭ-ийн Хорооны дотоод дүрмийн 13 дугаар зүйлын 13.1,13.3 заалтуудын дагуу ҮЭ-ийн Хорооны удирдлага, шийдвэр гаргах эрхийг ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗӨВЛӨЛ хэрэгжүүлнэ.

- ҮЭ-ийн Хорооны дотоод дүрмийн 18 дугаар зүйлын 18.1,18.5 заалтуудын дагуу Тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэр тогтоол, хэрэгжилт, санхүүгийн орлого, зарлага мөн даргын ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих эрх, үүргийг ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ хэрэгжүүлнэ.

# 2025 ОНД ХИЙГДСЭН ХУРАЛ УУЛЗАЛТУУД

(*ТООН ҮЗҮҮЛЭЛТ*)

***ҮЭ-ийн Хороо нийт_132 хуралд оролцсон:***

- Тэргүүлэгчдийн тогтмол онлайн хурал_**22**
- Бүх сонгуульт ажилтны нэгдсэн хурал_ **2**
- ҮЭ-ийн Хорооны комисс, хороо, ажлын хэсгийн хурал_**39**

***Ажил олгогчтой нийт_54***

- АО-ҮЭХ-ны сар бүрийн хуваарьт хурал_**12**
- Хэлтэс хариуцсан менежерийн хурал_**32**
- Хэлтсийн ерөнхий менежерийн хурал_**8**
- "Хамтын гэрээ"-ний хэрэгжилт дүгнэх хурал_**2**

***МҮЭ-ийн Холбоо, МЭХГГУУ ҮЭ-ийн Холбоо***

- Төв Холбооны хурал_**3**
- Салбарын Холбоо, Салбарын хэлэлцээр_**12**

***ҮЭХ-ны Хорооны:***

- Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс
- ҮОХХ-ыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс
- ЭМАА-ны Хороо
- Хувийн хамгаалах хэрэгслийн хороо /PPE/
- Хоолны хороо
- Цагийн бүртгэл, цалин бодолтын систем сайжруулалтын ажлын хэсэг
- Оператор болон техник мэргэжлийн ажлын байрны ур чадварын ялгааг нягтлах ажлын хэсэг
- Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний ажлын хэсэг зэрэг байнгын ажиллагаатай **2** комисс, **3** хороо, **3** ажлын хэсэг шаардлагатай үед хуралдаж цаг үеийн асуудлыг тухай бүрд шийдвэрлэж ажилладаг.

# АЛБАН БИЧИГ, САНАЛ ХҮСЭЛТ

**Нийт албан бичиг_ 69**

- Явсан албан бичиг_44
- Ирсэн албан бичиг_25
- Тэргүүлэгчдийн тогтоол_65
- Хяналтын хорооны тогтоол_4
- Хурлын тэмдэглэл_83
- Сонгуулийн комиссын шийдвэр_2
- Ирсэн мэйл_2753
- Явсан мэйл_1726
- ҮЭ-ийн Хорооны үйл ажиллагааны тайлан_12
- НД тайлан_2
- Санхүүгийн тайлан_2

**Гишүүдээс ирсэн өргөдөл, санал хүсэлт_157 хүний 37 асуудлаар**

/2024 онд_667 , 76.46% буурсан /

- санал гомдол шийдэгдсэн _33
- удирдах ажилтантай холбоотой_18
- сонгуульт ажилтны тухай_1
- эрүүл мэндийн даатгал_1
- чөлөө олгох журам_2
- Ээлж хүлээлцсэний нэмэгдэл_11
- санал гомдол хүлээгдэж буй_63

Үүнээс:

- ажилд ирсэн замд явсан цагийн цалин хөлс тооцуулах_46
- Хяналт шалгалтын явцад_11
- ажлаас халагдсан тухай_5

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ
## *(тоон үзүүлэлт)*







- www.ottu.mn цахим хуудсанд тавигдсан мэдээлэл_**20**
- www.ottu.mn цахим хуудсанд шинэ гишүүнээр элсэх анкет харагдах байршил болон агуулгын өөрчлөлт хийсэн.
- Цахим хуудаст 2025-2027 оны Хамтын гэрээг байршуулав.
- Цахим хуудаст 2024 оны 2 улирлын санхүүгийн тайланг бүрэн эхээр нь байршуулав.
- Цахим хуудсын хандалт_**145888**
- Мессеж мэдээлэл бүх гишүүдэд_**2**
- Мессеж санал асуулга бүх гишүүдэд _**2**
- ОТ ҮЭХОРОО ТАТВАР ТӨЛӨГЧДИД ФБ группэд тавигдсан мэдээ пост _**85**

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧИД 2022-2026 ОНД 2 ХАМТЫН ГЭРЭЭ, 1 ТОХИРОЛЦООНЫ ГЭРЭЭ ХИЙСЭН АМЖИЛТТАЙ

- 2021 оны 12 сард ҮЭ-ийн гишүүд сайн дурын санаачлагаар Хяналтын Хорооны **5** гишүүний сонгуулийг амжилттай зохион байгуулав.
- 2022 оны 1 сард Хяналтын хороо Тэргүүлэгчдийн сонгуулийг амжилттай хийж **17** тэргүүлэгч сонгов.
- 2023 онд Тэргүүлэгч гишүүн ҮЭ-ийн Хорооны даргыг **1,6** жил орлон гүйцэтгэж ажиллав.
- ҮЭ-ийн Хорооны дотоод дүрмэнд өөрчлөлт оруулан МҮЭ, ЭХГУУҮЭ-ийн Холбоонуудын дүрмийн дагуу сонгуульт ажилтны сонгуулийн хугацааг **4** жил болгов.
- 2024 оны 6 сард ҮЭ-ийн Хорооны орон тооны дарга компанийн үндсэн ажилтанаас сонгогдов.
- 2024 онд Санхүүгийн журмыг шинээр хийж, баталгаажуулан хэрэгжүүллээ.
- 2022 онд Ажил олгогчтой **7** дах Хамтын гэрээг байгуулав.
- 2023 онд Геологи, Уул уурхай, Хүнд үйлдвэрийн салбарын 2023-2024 оны Хамтын хэлэлцээрт анх удаа Тэргүүлэгч гишүүн оролцов.
- 2024 оны 4 сард дундаж цалин хөлс түүнтэй хамаарах "Хамтарсан ажлын хэсгийн тохиролцоо"-г хэрэгжүүлэх гэрээг хийсэн.
- 2024 онд ОТОНАҮЭ-ийн Хороотой анхны уулзалт хийж, "Хамтын гэрээ"-ний төсөлд хамтран ажиллав.
- 2024 онд Ажил олгогч, ОТОНАҮЭ-ийн Хороо 3 тал хамтарсан **8** дах удаагийн 2025-2027 оны Хамтын гэрээ байгуулав.
- 2025 оны 12 сард Хяналтын хорооны нөхөн сонгууль амжилттай явагдаж 2 гишүүн сонгогдов.

# СОНГУУЛЬТ АЖИЛТНУУДЫН НЭГДСЭН ХУРАЛДААН 2025.03.18




*2025 оны 3 дугаар сарын 18,19,20,21-ны өдрүүдэд хуралдав.*

- *Хуралд **14** Тэргүүлэгч, Хяналтын хорооны **3** гишүүн оролцож, **82,3%**-ийн ирцтэй зохион байгуулагдав.*

*Тус хуралдаанаар:*

- *2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж дүгнэн, Хяналтын хорооны аудитын тайлангаар илэрсэн зөрчил, зөрчлийг арилгах арга хэмжээг хэлэлцэн, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв зарцуулалтыг хэлэлцэж баталлаа.*
- *Гишүүдийн бүртгэл, татвар төлөлтийг хянан баталгаажуулж, тойрог хуваалтыг шинэчлэн хийв.*

# СОНГУУЛЬТ АЖИЛТНУУДЫН НЭГДСЭН ХУРАЛДААН 2025.11.17



2025 оны 11 дүгээр сарын 17, 18, 19-ны өдрүүдэд нэгдсэн хуралдааныг **16** Тэргүүлэгч, Хяналтын хорооны **3** гишүүн оролцож ирц 95,0%-ийн ирцтэй хийлээ.

Хуралдаанаар:

- Хяналтын хорооны аудит шалгалтын тайлан, өмнөх шалгалтаар илэрсэн зөрчлийн тайланг хэлэлцэн, үүрэг даалгаварын биелэлт **76,6%**-ийн гүйцэтгэлтэй гэж дүгнэв.
- ҮЭ-ийн Хорооны 2025 оны үйл ажиллагааны ололт амжилт, санхүүгийн урьдчилсан тайлангаар хэмнэлт гаргасан зардал зэргийг дүгнэн хэлэлцэв.
- ҮЭ-ийн Хорооны дотоод дүрэм, ёс зүйн журам, санхүүгийн журам, Хяналтын хороо, Тэргүүлэгчдийн сонгуулийн журмуудыг дахин хэлэлцэж өөрчлөлтүүд оруулан батлав.

# 2025-2027 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ДҮГНЭЛТ 2025 ОНД

*"Оюу Толгой" ХХК болон УУАҮЭХ, ОНАҮЭХ хамтран 2025.12.04-ны өдрийн хурлаар "Хамтын гэрээ"-ний 76 заалт 7 дэд заалтууд нэмэгдэж нийт 83 заалтын хэрэгжилтийг 97,6% гэж дүгнэв.* (*эх сурвалж ажил олгогчийн мэдээллээс*)

*Хамтын гэрээний доорх заалтуудыг:*

| ХГ заалт | Хэрэгжилтын хувь | Авах арга хэмжээ |
|---|---|---|
| *4.3 Цалин хөлс бодолт* | | *хэрэгжилтийг сайжруулахаар тохиров* |
| *4.11 Жилийн урамшуулал тооцох аргачлал* | *50%* | *хэрэгжилтийг сайжруулахаар тохиров* |
| *5.5 Гуравдагч байгууллагын хөнгөлөлт урамшуулал* | *75%* | *хэрэгжилтийг сайжруулахаар тохиров* |
| *8.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал* | *50%* | *хэрэгжилтийг сайжруулахаар тохиров* |
| *8.2 Ажлын байрны сайжруулалт* | *75%* | *хэрэгжилтийг сайжруулахаар тохиров* |
| *8.4 Хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгсэл* | *50%* | *хэрэгжилтийг сайжруулахаар тохиров* |

# *ХАМТЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ* *(эх сурвалж ажил олгогчийн мэдээллээс)*



# 2025-2027 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ДҮГНЭЛТ 2025 ОНД *(эх сурвалж ажил олгогчийн мэдээллээс)*

| Цалин, нэмэгдэл хөлс | ХГ-ний заалт | Хэрэгжилт 2025 онд |
|---|---|---|
| Үндсэн цалингийн нэмэгдэл | 4.1 | 2025 оны 3 сарын 1-нээс нийт ажилтны үндсэн цалинг 200 ам.доллараар нэмсэн |
| Цалингийн судалгаа | 4.2 | Тус судалгааг 2025 оны 1 дүгээр улирлын хурлаар танилцуулсан |
| Илүү цагийн нэмэгдэл хөлс | 4.4 (1) | 4090 ажилтанд тус нэмэгдэл хөлсийг олгосон |
| Шөнийн ээлжийн нэмэгдэл хөлс | 4.4 (2) | 3782 ажилтанд тус нэмэгдэл хөлсийг олгосон |
| Нийтээр амрах баярын өдрийн нэмэгдэл хөлс | 4.4 (3) | 3793 ажилтанд тус нэмэгдэл хөлсийг олгосон |
| Хоол унааны хөнгөлөлт | 4.5 (2) | 955 ажилтанд тус хөнгөлөлтийг олгосон |
| Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл | 4.9 | 3000 ажилтанд тус нэмэгдлийг олгосон |
| Засвар үйлчилгээний зогсолтгүй үйл ажиллагааны нэмэгдэл | 4.10 | 2753 ажилтанд тус нэмэгдлийг олгосон |

# 2025-2027 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ДҮГНЭЛТ 2025 ОНД *(эх сурвалж ажил олгогчийн мэдээллээс)*

| Тэтгэмж, урамшуулал | ХГ-ний заалт | Хэрэгжилт 2025 онд |
|---|---|---|
| Жилийн урамшуулал | 4.12 | Нийт ажилтанд уг урамшууллыг олгосон |
| Удаан хугацаанд ажилласан жилийн урамшуулал | 4.13 | 202 ажилтанд тус урамшууллыг олгосон |
| Тэтгэвэр хуримтлалын сан | 5.1 | Компани 4232 ажилтанд хуримтлал олгосон |
| Төрийн болон салбарын шагнал | 5.6 | 6 ажилтанд мөнгөн шагналыг олгосон |
| Гашуудлын тэтгэмж | 5.8 | 77 ажилтанд тус тэтгэмжийг олгосон |
| Тэтгэвэрт гарсан ажилтанд олгох тэтгэмж | 5.12 | 1 ажилтанд тус тэтгэмжийг олгосон |
| Үндсэн асран хамгаалагчийн /ээжийн/ чөлөө | 5.9 | 56 ажилтанд чөлөөний олговрыг олгосон |
| Шинээр хүүхэдтэй болсон эцэгт олгох чөлөө | 5.10 | 225 ажилтанд чөлөөний олговрыг олгосон |

# *ЭРҮҮЛ МЭНД, ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛ 2025*

*“Оюу толгой” ХХК ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд үргэлж эрхэмлэн ажилладаг билээ. Энэ хүрээнд ажилтан, түүнээс гадна гэр бүлийн **2** гишүүнийг тус даатгалд хамруулах тухай Хамтын гэрээнд оруулсанд нийт ажилтнууд сэтгэл хангалуун байдаг.*

***2024, 2025** онд ажилтнуудын Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын үйлчилгээг “Мандал” даатгалтай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна. Ажилтны даатгалын хамгаалалт **50,000,000** сая төгрөг бөгөөд эмчийн анхны үзлэгийн мөнгөнөөс бусад бүх эрүүл мэндийн асуудлын төлбөр бүрэн нөхөн төлөгддөг. Үүнд:*

- *Хэвтэн эмчлүүлэх эмчилгээ, үйлчилгээ*
- *Амбулаторийн үзлэг оношилгоо*
- *Архаг хууч эмгэгийн менежмент*
- *Жирэмслэлт, төрөлт*
- *Нүд, шүдний эмчилгээ*
- *Урьдчилан сэргийлэх үзлэг*
- *Хорт хавдрын хамгаалалт*
- *Гэнэтийн ослын даатгалын хамгаалалт*
- *Бусад хамгаалалт уламжлалт, вакцинжуулалт, сэтгэц, протез, оршуулгын зардлууд хамаарна*
- *Ажилтнууд гэр бүлийн гишүүн нэмэлтээр даатгуулах тохиолдолд хөнгөлөлт эдэлнэ*

# ***Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд***

- *Компани 4625 ажилтан, 9250 гэр бүлийн гишүүн даатгалд хамруулна*




*Ажилтнууд сайн дураар хөнгөлөлттэй нөхцөлөөр 138 гэр бүлийн гишүүнийг нэмж даатгуулсан.* (***эх сурвалжийг ажил олгогчийн мэдээллээс***)

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДОТООД ДҮРЭМ ЖУРАМ ШИНЭЧЛЭЛ.


"Оюу Толгой" ХХК-ийн Уул, уурхайн ажилтны ҮЭХ-ны Тэргүүлэгчдийн 2023 оны ... дугаар сарын ...-ны 16 дугаар тогтоолын хавсралт

ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН УУЛ, УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ ДОТООД ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАЛТ

Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

Хоёрдугаар зүйл. Эрхэм зорилго


"ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО"-НЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Ерөнхий зүйл

ҮЭ-ийн хорооны ёс зүйн дүрэм

- 2023 онд батлагдсан "ҮЭХ-ны дотоод дүрэм"-ийн зарим зүйл, заалтыг тодруулан өөрчлөлт оруулав.
- 2024 онд батлагдсан "Санхүүгийн журам"-ыг шинээр боловсруулж, батлан хэрэгжүүлэв.
- 2015 оны "Сонгуульт ажилтны ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн найруулав.
- 2022 оны "Сонгуулийн журам"-ыг шинэчлэн батлав.
- 2025 онд "Архивын журам"-ыг шинээр боловсруулж, хэрэгжүүлэв.


2024 оны Арван нэгдүгээр сарын ...ны өдөр Тэргүүлэгчдийн нэгдсэн хурлаар батлав.

"ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО"-НЫ САНХҮҮГИЙН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмаар Оюу толгой ХХК-ийн уул уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хорооны санхүүгийн харилцааг зохицуулахад оршино.


"ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО"-НЫ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН СОНГУУЛИЙН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл. Журмын зорилт

Энэхүү журмын зорилт нь Оюу толгой ХХК-ийн Уул, уурхайн ажилтны ҮЭХорооны Тэргүүлэгч гишүүдийг сонгох үндсэн зарчим, журмыг тодорхойлох, Тэргүүлэгч гишүүнд нэр дэвших, сонгох, сонгогдох эрхийг хангах, сонгуулийг зохион байгуулж, явуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 дугаар зүйл Нэр томьёоны тодорхойлолт


2025 оны 11 сарын 18-ны тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж ....дугаар тогтоолоор батлав.

"ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО"-НЫ МЭДЭЭЛЭЛ, БИЧИГ БАРИМТ, АРХИВЫН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмаар Оюу толгой ХХК-ийн уул уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хорооны бичиг баримт, мэдээллийн хөтлөлт, хадгалалт, хамгаалалт, харилцлагын талаарх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү журмыг ҮЭ-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгоно.

Хоёр. Бичиг баримт хөтлөлт

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ХЯНАЛТЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

*Хийсэн хяналт шалгалт* **2025.3.14**









*Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгасан, эвдэрсэн өмч хөрөнгийг засуулан ашиглалтанд оруулсан тухай ҮЭ-ийн Хорооны ирүүлсэн тайлангаар* ***71.4%*** *-ийн гүйцэтгэлтэй гэж дүгнэв.*

- *Бичиг баримтуудын ангилалт, хадгалалт хөтлөлт сайжирсан:*
- *Ирсэн явсан бичгийг он сар өдөр дараалльн дагуу ангилан ялгаж, товьёог хөтөлсөн*
- *Санхүүгийн бичиг баримтууд болох Тэргүүлэгчдийн тогтоол, нэхэмжлэх, гүйлгээний баримтуудын бүрдэл сайжирч, мөн тус тусад нь жагсаалтуудыг хөтөлсөн*
- *Тэргүүлэгчдийн тогтоолуудын гарын үсгийн бүрдэл сайжирсан*
- *Хороонд ирсэн гомдлуудыг бүртгэж, хэрхэн шийдвэрлэсэн талаар тэмдэглэж, жагсаалт хөтөлсөн*
- *Санхүүгийн гүйлгээ бүрийн өмнөх Тэргүүлэгч гишүүдийн тогтоол бүрэн*
- *Өмч хөрөнгийн тооллогыг гүйцэтгэж, жагсаалтыг шинэчлэн бий болгосон*
- *Эрсдлийн сан нээж 300 сая төг хадгалуулж, өсгөх боломжтой болсон*

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ХЯНАЛТЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

*Хийсэн хяналт шалгалт* **2025.11.16**



ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ
ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

2025 оны 11 сарын 16 өдөр — Дугаар 02 — Улаанбаатар хот

/Төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн тухай/

**1. Хяналт шалгалтын зорилго**

Хяналт шалгалтын зорилго нь "Оюу толгой ХХК-ийн Уул уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хорооны дотоод дүрэм"-ийн 18.4, 18.5-д заасны дагуу хорооны санхүүгийн үйл ажиллагаа, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, гишүүдийн өргөдөл гомдол санал хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, олонт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгахад оршино.

**2. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн**

Хяналтын зөвлөлийн гишүүн Р. Анхжаргал, Б. Цогбадрах, Б. Болорцэцэг

**3. Хугацаа**

Хяналт шалгалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 14-17 цагийн хооронд Үйлдвэрчний эвлэлийн хорооны байранд явуулав.

**4. Хяналт шалгалтын хамрах хүрээ**

Хяналт шалгалтын хүрээнд 2025 оны эхний 10 сарын Үйлдвэрчний хорооны бүх тогтоол шийдвэрүүд, орлого, зарлагын гүйлгээний үндсэн баримтууд, бараа материалын худалдан авалтын бичиг баримтууд, санхүүгийн бичиг баримт, гэрээнүүдийг хянаж үзлээ. Хяналт шалгалтыг дараах чиглэлүүдээр явууллаа.

- Хяналтын зөвлөлөөс явуулсан 2025 оны 3 сарын 14-ний өдрийн хяналт шалгалтын биелэлт
- Кассын гүйлгээний 200.000 төгрөгөөс дээш гүйлгээ болон харилцах дансны 500.000 төгрөгөөс дээш гүйлгээнүүд



ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН
УУЛ, УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОРОО

он 2025 сар 11 өдөр 05
№ [illegible]
Улаанбаатар хот

ХЯНАЛТЫН ХОРООНД

*Хяналт шалгалтын зөрчил арилгасан тухай*

Хяналтын хорооноос ҮЭ-ийн Хорооны дотоод үйл ажиллагаа, санхүү зарлага, эд хөрөнгийн бүртгэл зэрэг гишүүдийн хураамж зөв зохистой зарцуулагдаж байгаа тухай хяналт аудит хийж, ололттой сайн талуудыг үнэлэн, зөрчил дутагдлыг илрүүлэн, цаашид сайжруулах арга зөвлөмж гаргасан та бүхэнд талархал илэрхийлье.

ҮЭ-ийн Хорооны ажлын алба 2025 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн Хяналтын хорооны хяналт аудитаар гарсан зөрчил, зөрчлийг арилгах үүрэг чиглэл өгсөн дагуу доорх арга хэмжээг авч ажилласан болно.

Үүнд:

1. Эд хөрөнгийн ашиглалт, хадгалалтын талаар 4 төрөл зүйлийн зөрчлийг зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэгч "Мэжик консалтинг"ХХК-ийн заавар зөвлөмжийн дагуу арилгасан.
2. Бичиг баримт, архивын бүрдэлд 6 төрөл зүйлийн зөрчлийг Тэргүүлэгчдээр гарын үсэг зуруулах, гэрээний дугаар давхардал, харилцагч байгууллагын гэрээг он тус бүрээр архивлан цэгцлэсэн.
3. Санхүү зардал, зарлагын гүйлгээний 6 төрөл зүйлийн зөрчлийг "Global vision" LLC-ийн 2024 оны OTTU.mn веб сайтын засвар үйлчилгээний гэрээ, "Klair Laiks" LLC оффис түрээсийн гэрээ, "Novus Loo" LLC-ийн хуулийн зөвлөх үйлчилгээний гэрээ тус тус өөр архивд хадгалсан байсан. Хувь хүний данс руу гүйлгээ хийгдсэн 3 төрөл зүйлийн зөрчилд байгууллагын санхүүд хэмнэлт хийх, байгууллагын картыг гадаадын компанитай /Docusign, Zoom/ холбоот хийж гүйлгээ хийх нь эрсдэлтэй гэж үзсэний улмаас хийгдсэн болно.

Тус хяналт шалгалтаар шинээр үүрэг болгосон:

1. ҮЭ-ийн Хороонд огт хийгдэж байгаагүй Тэргүүлэгчдэд хуралд оролцох, хамтын гэрээ байгуулах үеийн урт хугацааны бууддын төлбөр, тээврийн зардлын үнэ зэрэг ЗГ-аас мөрдөх томилолтын зардлын жишиг үнэ мөрдүүлэх тухай

Хаяг: Улаанбаатар-14240, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,

- Санхүүгийн гүйлгээ бүрт тэргүүлэгчдийн тогтоолын дугаарыг оруулах.

  Байгууллагаас ирсэн нэхэмжлэхийн дүнг нягтлан шалгах

  НӨАТ баримт өгдөггүй үйлчилгээнүүдийг сард дунджаар баримжаалан тэргүүлэгчдийн тогтоолоор баталгаажуулах, санхүүгийн журамд зохицуулалт хийх жишээ нь:такси үйлчилгээ

  Тэргүүлэгчдийн урамшуулалт цалинг (сард 150,000, жилд 1.800.000 төг) гүйцэтгэлтэй нь холбож олгох талаар хурлаараа хэлэлцэж шийдвэрлэх

  Өндөр үнэтэй бараа, ажил үйлчилгээ худалдан авах, гэрээ хийхдээ хэд хэдэн байгууллагуудаас үнийн санал авч, сонгох ажлыг хэрэгжүүлэх

  Худалдан авалтын үнийн дүнг зааж, гэрээ, санал авахгүй байх тухай зохицуулалт хийх

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ГИШҮҮДЭД ЗОРИУЛЖ ХИЙГДСЭН АЖЛУУД

| | |
|---|---|
| 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах, мэдээлэл өгөх | ottu.mn вэб хуудаст мэдээлэл оруулсан: 2024 үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, орлого зардлын гүйцэтгэл |
| 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө танилцуулах | ottu.mn вэб хуудаст мэдээлэл оруулсан. |
| Хүний эрх, Хөдөлмөрийн эрх зүй, Нийгмийн даатгал татварын хуулийн видео сургалтууд хийх | 2025.09.26 15:00. ЧД-ийн НДХ Сургалт хариуцсан мэргэжилтнүүд: уурхайд ажиллагсдын тэтгэвэр тогтоолгох тухай хийгдсэн |
| Гишүүдэд зориулан жилд 2 удаа аялал зохион байгуулах | Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн Спортын тэмцээн уралдаан зохион байгуулахаар шийпвэрлэсэн, санхүүгийн тайланд үндэслэн |
| Мандал даатгалын үйлчилгээ “Нөхөн төлбөр олгох байдал”-ыг тухай санал асуулга авах | ЭМД-тай холбоотой 2 гомдол ирсэн тул санал асуулга хийгдээгүй |

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ГИШҮҮДЭД ЗОРИУЛЖ ХИЙГДСЭН АЖЛУУД

| | |
|---|---|
| *Ажил олгогчоос "Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг"-ийн чанарын талаар санал асуулга авах* | *АО: үзлэгийн чанар сайжруулах тухай хурлаар мэдээлэл өгсөн. Тэргүүлэгчдийн хуралд мэдээлэл өгсөн* |
| *Тэргүүлэгчид тойрог хуваалтын тухай тойрогтоо мэдээлэл өгөх,* | *Компанийн бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан тухай бүрд тойрог хуваалтын өөрчлөлт хийгдэж байна.* |
| *ҮЭ-ийн Хорооны цаг үеийн ажлаар тогтмол мэдээллэх* | *Мэдээлэл тухай бүрт хийгдэж байгаа цаашид сайжруулалт хийх шаардлагатай* |
| *Хяналтын Хорооны үйл ажиллагааны тухай мэдээлэл өгөх* | *Тухайн жилийн үйл ажиллагааны тайлангаар өгөгдөж байна.* |
| *ҮЭ-ийн Хорооны дарга, тэргүүлэгч тойргоор уулзалт хийх* | *6, 10-р тойргийн гишүүдтэй 4 удаа уулзалт зохион байгуулсан. Сар бүр 7 хоног уурхайд ажиллахаар шийдвэрлэгдсэн .* |

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ГИШҮҮДЭД ЗОРИУЛЖ ХИЙГДСЭН АЖЛУУД

| | |
|---|---|
| Байгууллагуудтай хийсэн хөнгөлөлт урамшууллын талаар тодорхой мэдээлэл гаргах | Хужирт тур, Ретро майнд, ЭОМЭН, Гялалзахын хөндий зэрэг ХХК-тай амралт, рашаан сувилал, жим фитнесийн чиглэлээр хөнгөлөлт урамшууллын гэрээ хийгдсэн. Мэдээллүүд тухай бүр орж байгаа |
| Тойрог бүрд идэвхтэн гишүүн ажиллуулах | Цалин урамшууллын асуудал шийдвэрлэх шаардлагатай |
| Хөдөлмөрлөх эрхээ хамгаалах өдрийг тэмдэглэх (6 сарын 13) | Уурхайд 2024 оны тайлангийн хурал хийсэн ирц хангалтгүй. |
| Шилдэг ҮЭ-ийн Хороодын туршлага мэдээлэл судлах, хамтран ажиллах, нэвтрүүлэн хэрэгжүүлэх | Сонгуульт ажилтнуудын хэмжээнд туршлага судлах ажил хийгдээгүй, Дарга дээд шатны байгууллагын хурал уулзалтуудаар туршлага судлан, мэдээлэл солилцон ажиллаж байна. |
| ОТ УУА ҮЭХороо Хөдөлмөрлөх эрхээ хамгаалах өдөрлөгийг жил бүрийн 6-р сарын 13ны өдөр тэмдэглэхээр тогтож Спортын арга хэмжээ уурхайн цогцолборт зохион байгуулагдана. | Амжилттай хийгдсэн. Нийт 343 гишүүд тамирчид оролцон, 47,995,603 мнт зардал гарсан |

# *Гишүүд ажилтнуудад зориулсан спортын арга хэмжээ*

*Уурхайн цогцолборт ҮЭ-ийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор* ***2025*** *оны* ***8*** *сарын* ***5-11*** *хооронд* ***4*** *төрөлт спортын арга хэмжээ зохион байгуулав. Тэмцээнд* ***3×3*** *сагс төрөлд* ***30*** *баг, волейбол* ***9*** *баг, мобайл лежендс* ***32*** *баг, дартс холимог хос төрөлд* ***25****, ганцаарчилсан төрөлд* ***64*** *тамирчин тус тус бүртгүүлэн нийт* ***358*** *тамирчин оролцож, тамирчин оролцож, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөн шилдэг баг, тамирчид тодров.*



**“ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ НЭРЭМЖИТ СПОРТ ӨДӨРЛӨГ**

| | |
|---|---|
| **Хэзээ:** | 2025 оны наймдугаар сарын 5-11-ний өдрүүдэд |
| **Хаана:** | “Оюутолгой” уурхайн цогцолборт |
| **Хамрах хүрээ:** | Нийт ажилтан |
| **Төрөл:** | Сагсан бөмбөг 3Х3, Волейбол, Дартс, Mobile legends |

- Сагс эрэгтэй, эмэгтэй баг
- Волейбол эрэгтэй, эмэгтэй баг
- Mobile legends холимог баг
- Дартс ганцаарчилсан болон хосын

| | |
|---|---|
| **Багийн мэдүүлэг:** | Наймдугаар сарын 1-ний өдрөөр дуусгавар болгоно BilguunErd@ot.mn alimaam@ot.mn хаягаар багийн мэдүүлгээ илгээнэ. |
| **Техникийн зөвлөгөөн:** | Наймдугаар сарын 2-ны 19.00 цагаас Спорт төвд |

**Шагнал:**

| | |
|---|---|
| **Сагс, волейбол:** | Өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал |
| **Дартс:** | Өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал |
| **Mobile legends:** | Өргөмжлөл, мөнгөн шагнал |
| **Шилдэг тоглогч (сагс, волейбол):** | Цом, батламж |

**Бүртгэл мэдээлэл өгөх:**

| | | |
|---|---|---|
| • Сагс | Г.Билгүүдэй | 99014135 |
| • Волейбол | Ц.Очирбат | 99077836 |
| • Mobile legends | Б.Наранбаяр | 95091792 |
| • Дартс | С.Эрдэнэтайван | 99132732 |

**Зохион байгуулагч:** “ОюуТолгой” ХХК-ийн Уул Уурхайн Ажилтны Үйлдвэрчний Эвлэлийн Хороо





# *Гишүүд ажилтнуудад зориулан эрүүл мэнд, амьдралын хэв маягийг дэмжих хөнгөлөлт*




*"ХУЖИРТ ТУР" ХХК буюу "ХАН ХУЖИРТ" амралт, рашаан сувиллын цогцолбортой хамтран ажиллах, тус амралт сувиллын үйлчилгээнд "ОЮУ ТОЛГОЙ" ХХК-ийн ажилтнууд* **10%**-*ийн хөнгөлөлт эдлэх гэрээг эцэслэн хийллээ.*

*"Ретро майнд" ХХК-ийн "GUM HUB" хөтөлбөрийг дэмжин, жим фитнес, йог, бясалгалын чиглэлээр хөнгөлөлт урамшууллын гэрээ хийн жилийн турш* **480-780** *мянган төгрөгийн төлбөртэй* **20** *гаруй байгууллагаас сонгон хичээллэх боломжийг олгосон. САП дугаар бүхий үндсэн болон гэрээт ажилтнууд бүхд хамрагдах боломжтой. Бүртгэл баталгаажсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд үйлчлүүлэх эрхтэй.*



# Гишүүд ажилтнуудад зориулан эрүүл мэнд, амьдралын хэв маягийг дэмжих хөнгөлөлт




*"Airman" ХХК-ийн бүтэн биеийн шинжилгээтэй Сөүл аялалд ОТ ХХК-ийн үндсэн болон гэрээт ажилтнуудад **10%**-ийн хөнгөлөлттэй хөтөлбөрт хамрагдах боломжтой гэрээ хийгдсэн.*




***Energy Hills 30% хөнгөлөлттэй амралт***

*Горхи-Тэрэлжийн Онгоцотын аманд байрлах "Energy Hills resort"-той 2026 оны 04 сарын 01-ны өдөр хүртэл Баасан, Бямба гаригаас бусад өдрүүдэд цомцог гэр болон хаусанд 30% хөнгөлөлттэй амрах боломжийг олгосон хамтран ажиллах гэрээ байгуулав. Тус хөнгөлөлтөд "Оюу Толгой" ХХК-ийн үндсэн болон туслан гүйцэтгэгч байгууллагын ажилтнууд, тэдний гэр бүлийн гишүүд хамрагдах боломжтой бөгөөд САП дугаар бүхий ажилтны үнэмлэхтэй байна.*

*Манай цомцог гэр болон дулаахан хаусууд танд байгалийн сайханд амрах төгс боломжийг олгож байна!*

- *Баасан, Бямба гаригаас бусад бүх өдөр*

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

## Сонгуульт ажилтнуудад зориулсан ажил

| | |
|---|---|
| Тэргүүлэгчид, Хяналтын Хорооны гишүүд МҮЭ, МЭХГУУ ҮЭ-ийн Холбооноос зохион байгуулагдах сонгуульт ажилтны сургалтуудад хамрагдах. ⇒ | Ажлын албанаас зохих сургалт, зөвөлгөөнд идэвхитэй оролцож байна. |
| Сар бүрийн менежертэй хийх уулзалтыг үр дүнтэй хийх, бусад тойргоос туршлага хуваалцах ⇒ | Сар бүрийн уулзалтууд үр дүнтэй байгаа тухай хурлуудаар хэлэлцэн, олонхийн саналаар уг хурлыг үргэлжлүүлэн хийж байгаа. |
| Тэргүүлэгчид ажлын тайлан тойрогтоо танилцуулах ⇒ | Тойргын ФБ групп-т шинэчлэл хийгдэж байна. |
| Шинэчлэн найруулах хуулийн төслүүдэд гишүүдийн санал авч нэгтгэн, зохих байгууллагад уламжлах ⇒ | МҮЭ-ийн эрхийн тухай хуульд давхар гишүүнчлэлийг зөвшөөрөхгүй байх, ‘’Хамтын гэрээ’’-ний үйлчлэх хүрээг тогтоох, зөвхөн ҮЭ-ийн гишүүнд үйлчлэх тухай санал явуулсан. |
| Тэргүүлэгчид, Хяналтын Хорооны гишүүдэд ростерийн амралт, амралтын өдрүүдээр хурлын цалин урамшуулал олгох ⇒ | Цалин урамшуулал олгох хэлэлцүүлэн Санхүүгийн журамд оруулан хэрэгжсэн |

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

## Тойрог хуваалт, гишүүдийн мэдээлэл

| | |
|---|---|
| *2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл хэлэлцэв* ⟹ | *ҮЭ-ийн 2025 оны Хорооны үйл ажиллагаа тэлэвлэгээний дагуу хийгдсэн, Санхүүгийн төсөв зардлыг хэтрэлттэй баталсан болович тодорхой хэмжээний 25,0 сая орчим төг хэмнэлт гаргаж ажилласан. Гүйцэтгэл сайн гэж үнэлэв.* |
| *Тойрог хуваалт шинэчлэлт хийх* ⟹ | *Компанийн бүтцийн бүтэц, зохион байгуулалт ойрхон өөрчлөгдөж байгаатай холбоотой 2025.03.21/2025.11,18 нд хийгдсэн, УБ-оффист, Ил уурхайд нэг нэг тойрог нэмэх.* |
| *Ажил олгогчоос бүх гишүүдийн шинэчилсэн мэдээлэл авах* ⟹ | *Хорооны гишүүдийн бүртгэл шалгах, баталгаажуулах, хураамж төлсөн мэдээлэл сар бүр ирүүлж хэвшсэн.* |
| *Компаний бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн мэдээлэл авах* ⟹ | *2025.02.25 авсан, 2025.11.18 нд Бүтцийн өөрчлөлтийн мэдээлэлүүд дэлгэрэнгүй ирүүлсэн.* |
| *Тойргуудыг ФБ групп үүсгэн, гишүүдийг хувиарлах* ⟹ | *Нийт 2000-1223 гишүүнтэй холбогдон хаяг тодруулга хийгдсэн. Нэг хаягаас олон хүсэлт чат илгээхэд ФБ-ээс хязгаарлалт хийж байна. ФБ хэрэглэдэггүй, аксепт хийж чадахгүй гэсэн тайлбарууд байна.* |

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

## *Хамтын гэрээ санамж бичгийн дагуу хийгдсэн ажлууд*

| | |
|---|---|
| *Тэргүүлэгчид хэлэлцэх асуудлаа ҮЭ-ийн Хорооны даргатай хэлэлцэж, мэдээлэл солилцох* → | *Хэрэгжиж байна. 9 сараас хурлуудад Дарга оролцоод явж байна.* |
| *Хэлтсийн менежерийн уулзалт болон ҮЭ-ийн Хорооны комисс, хороо, ажлын хэсгийн хурлуудаар хэлэлцсэн асуудлаар мэдээлэл хуваалцах* → | *Тэргүүлэгчдийн 14 хоног тутмын хурлаар мэдээлэл хийгдэж байна.* |
| *Сар тутмын АО-ҮЭ-ийн Хорооны даргын уулзалтад Тэргүүлэгчид саналаа хэрхэн оруулах,* → | *Саналыг е-мэйл, ФБ Тэргүүлэгчдийн грүппээр авч байна. Нэгдсэн дата мэдээлэлтэй болох* |
| *Хагас жил тутмын "Хамтын гэрээ"-ний хэрэгжилт дүгнэв* → | *2025.07.05/2025.12.04-ны өдрүүдэд 2 удаа хэрэгжилтыг дүгнэж 3 тал хамтран ажиллав..* |
| *2025.12.04 ны "Хамтын гэрээ"-ний хэрэгжилтийг 97,6% гэж дүгнэв* → | *2025.07.05 хийгдсэн АО-той. 2025.07.04_АО_Хамтын гэрээний хэрэгжилт_(1).pdf* |

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

## *Оффис хэрэглээний программ, үйл ажиллагаа явуулах*

| | | |
|---|---|---|
| *МТ мэргэжлийн ажилтантай гэрээгээр ажиллуулах* | ⟹ | *МТ ажилтантай дуудлагаар үйлчилгээ үзүүлэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан* |
| *Domain эрх мэйл хаягнууд шалгах, салгах хаалгах* | ⟹ | *Домайн хаяг шилжүүлсэн, Ottu.mn 7 мэйл хаягаас 4 хаяг хаалгасан* |
| *Microsoft office 365 авч хэрэглэх, teams, share folder* | ⟹ | *2 ш оффисс программ авч хэрэглэж байна. Teams, share folder 1TB хэвийн ажиллаж байна.* |
| *Шинэ принтер авах суурилуулах* | ⟹ | *Epson L6290 принтер авсан, ажиллагаа хэвийн.* |
| *Website хөгжүүлэлтэд сайжруулалт хийх* | ⟹ | *Website-д мэдээлэл оруулах админ эрх ажлын албанд авсан.* |

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ САНХҮҮ, ЭД ХӨРӨНГӨ






# *МҮЭ ХОЛБОО ХАМТЫН АЖИЛЛАГАА*




- ***2025.02.06*** *нд МҮЭ-ийн Төв Холбооноос Татварын багц хуулийн шинэчилсэн найруулгад санал оруулах тухай уулзалт*
- ***2025.6.24. 25*** *нд МҮЭ-ийн Соёлын төв ордонд МҮЭ-ийн* ***XXIV*** *дүгээр их хуралдзохион байгуулагдаж ҮЭХ төлөөлөгчөөр сонгогдон оролцов. Их хурлаар МҮЭ-ийн Ерөнхийлөгчөөр Б.Тамир сонгогдож, Тэргүүлэгчид, Хяналтын хорооны сонгууль явагдаж бүрэн бүрэлдэхүүнээр солигдлоо.*
- ***2025.10.08*** *нд МҮЭ Холбооноос ‘’Зохистой хөдөлмөрийг дэмжиж, нийгмийн шударга ёсыг хангуулъя’’ сэдэвт ҮЭХ-ны дарга, идвэхтэн сонгуультны улсын анхдугаар зөвөлгөөнүүдэд оролцов.*
- *МҮЭ-ийн Эрхийн тухай хуульд давхар гишүүнчлэл, ‘’Хамтын гэрээ’’-ний үйлчлэх хүрээг ХТХ-д зааснаар зөвхөн гишүүдэд үйлчлэх болгон тусгах тухай санал явуулсан.*

# Татварын багц хуулийн шинэчилсэн найруулгад санал оруулах тухай уулзалт

**2025.02.06 нд МҮЭ-ийн Төв Холбоо ҮЭ-ийн Хороодуудын төлөөлөлтэй хамтран МУ-ын ЗГ-т хүргүүлэв**

- Хувь хүний орлогын албан татвар ногдуулах жилийн орлогыг **0-120** сая төгрөгөөс эхэлж байгааг **0-60.0** сая төгрөг хүртэл **5%** байх шатлал бий болгох
- Байгууллагаас олгож байгаа хоол унааны мөнгөнөөс татвар авахгүй байх
- Орон сууцны татварын хөнгөлөлт урамшууллыг **6.0** сая байгааг нэмэгдүүлэх /**10** сая болгох/
- Хадгаламжийн хүүгийн орлогоос авах татварыг **100.0** сая төгрөгөөс дээш авах
- Татварыг шударга төлж байгаа иргэдэд татварын хөнгөлөлт үзүүлдэг байх /ажилтнууд цалингаас татвар төлөөд аливаа хөнгөлөлт, урамшуулал огт байдаггүй/
- НӨАТ-ын буцаан олголтыг **5%** болгох
- Одоогоор **50** сая төгрөгөөс дээш НӨАТ-ыг төлж байгаа босгыг нэмэх **200** сая төгрөгөөс дээш татвар төлж байх
- Эхчүүд, нярай хүүхдийн зориулалттай бараа бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлөх
- Импортын бараа бүтээгдэхүүн орлох болон экспортын бараа бүтээгдэхүүний үйлдвэр, үйлчилгээ үзүүлж байгаа, ажлын байрыг нэмэгдүүлж Аж ахуй нэгж байгууллагад тодорхой хэмжээнд татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх

# МЭХГУУ ҮЭ-ийн Холбоо хамтын ажиллагаа

- 2025-3-13 өдөр ҮЭ-ийн Холбооний Гүйцэтгэх Хорооны нэгдсэн хуралдаанд оролцсон бөгөөд 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэл дүгнэх, 2025 оны төсөв батлав.
- 2025-3-14 өдөр ҮЭ-ийн Холбооноос зохион байгуулсан ‘’Анхан шатны Хороодын Сонгуульт ажилтан’’-д зориулсан сургалтад хамрагдав.
- 2025-4.25.26.27-ны өдрүүдэд Олон Улсын Аж үйлдвэрийн ажилтны ҮЭ-ийн холбоо Industri ALL Global Union-оос Испани Улсын Мадрид хотноо зохион байгуулагдах ‘’Үндэстэн дамнасан корпораци’’-уудын тухай зөвлөгөөн уулзалтад ҮЭ-ийн Холбооноос 1 ажилтан, Хорооноос 2 ажилтан төлөөлөн оролцов.
- 2025.6.16 ‘’Оюу Толгой’’ ХХК-ийн Салбарын хамтын хэлэлцээрийн 2023-2024 оны биелэлтийг дүгнэж, ЭХГУУ ҮЭХ-нд явуулав.
- 2025.6.30 Геологи, Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023-2024 оны Хамтын хэлэлцээр дүгнэж, акт гаргав.
- 2025-7.6-10 ны хооронд БНСУ-д зохион байгуулагдсан Олон улсын ХАБЭА-н үзэсгэлэнд 2 Тэргүүлэгч оролцов.
- 2025.08.22 Салбарын хамтын хэлэлцээрт санал авах уулзалт зөвөлгөөнд Багануур ХХК-д оролцож санал хүргүүлж ажиллав.
- 2025 оны 9/10 сард Аж үйлдвэр, Эрдэс баялгийн салбарын 2026-2027 оны хамтын хэлэлцээрт ҮЭХ оролцож Хорооны чухал 2 асуудлыг хэлэлцээрт оруулав.
- 2025.9.25 ЭХГУУ ҮЭХ-той ‘’Хариуцлага үр дүнгийн гэрээ ‘’ хийж баталгаажуулсан. Холбоонд төлөх сарын татварыг 1,333,333 мнт –р шийдвэрлэв.
- 2025.10.30- нд Аж үйлдвэр, Эрдэс баялгийн салбарын 2026-2027 оны хамтын хэлэлцээр батлагдав.
- 2026 оноос эхлэн Монголын Уул уурхайн салбарын хамгийн том олон улсын чуулга уулзалт, үзэсгэлэн ‘’Mining week’’-д МЭХГУУ-н ҮЭ-ийн ХОЛБОО-г оролцуулан хамтарч хийх саналыг МУУҮА-с гаргалаа.

# МЭХГУУ-Н ҮЭ-ИЙН ХОЛБОО ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Гишүүд ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгааг хангах зорилгоор тус ҮЭ-ийн Хороо байгуулагдсан цагаас хойш Монголын  эрчим хүч, Геологи уул уурхайн ҮЭ-ийн Холбооны гишүүн байгууллагаар ажиллаж мэргэжил эрх зүйн зөвлөгөө авах, сургалт, зөвлөгөөнд оролцон, Холбооноос зохион байгуулах үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаж байна.*

***2025-3-13*** *Холбооны гүйцэтгэх хорооны нэгдсэн хуралдаанд оролцож, 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэл дүгнэж, 2025 оны төсөв батлав.*

***2025-3-14*** *Холбооноос зохион байгуулсан ''Анхан шатны хороодын сонгуульт ажилтан''-д зориулсан сургалтад хамрагдав.*

***2025-4-18*** *ХАБЭА-н Үндэсний хороо, Хөдөлмөрийн нийгмийн харилцааны дээд сургууль хамтран зохион байгуулсан ''ХАБЭА-н сайн туршлага'' арга хэмжээнд МЭХГУУ ҮЭХ болон ОТ ХХК УУАҮЭХ хамтран эрүүл, аюулгүй ажиллагааны чанар, стандартыг манлайлан хэрэгжүүлэгч Оюу толгой танилцуулга туршлага хуваалцан илтгэл тавьж оролцов.*

***2025-4.25.26.27****-ны өдрүүдэд Олон улсын аж үйлдвэрийн ажилтны ҮЭ-ийн Холбоо Industri ALL global union-оос Испани улсын Мадрид хотноо зохион байгуулагдах ''Үндэстэн дамнасан корпорац''-уудын зөвлөгөөн уулзалтад Холбооноос 1 ажилтан, Хорооноос 2 ажилтан төлөөлөн оролцов.*

***2025.6.16*** *''Оюу толгой'' ХХК-ийн салбарын хамтын хэлэлцээрийн* ***2023-2024*** *оны биелэлтийг дүгнэж, баталгаажуулан Холбоонд явуулав.*

***2025.6.30*** *Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын* ***2023-2024*** *оны хамтын хэлэлцээр дүгнэх хурал болов.*



# МЭХГУУ-Н ҮЭ-ИЙН ХОЛБОО ХАМТЫН АЖИЛЛАГАА








***2025-7.6-10**-ны хооронд БНСУ-д зохион байгуулагдсан Олон улсын ХАБЭА-н үзэсгэлэнд 2 тэргүүлэгч оролцов.*

***2025.08.22** Салбарын хамтын хэлэлцээрт санал авах уулзалт зөвлөгөөнд Багануур ХХК-д оролцож санал хүргүүлж ажиллав.*

***2025** оны **9/10** сард Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын **2026-2027** оны хамтын хэлэлцээрт оролцож ҮЭ-ийн Хорооны тулгамдсан **2** асуудлыг хэлэлцээрт оруулж, батлуулав.*

***2025.9.25** ЭХГУУ ҮЭХ-той "Хариуцлага үр дүнгийн гэрээ " хийж баталгаажуулсан. Холбоонд төлөх жилийн татвар төлөлт хийгдсэн.*

***2025.10.30**-нд Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын 2026-2027 оны хамтын хэлэлцээр батлагдав.*

***2026** оноос эхлэн Монголын Уул уурхайн салбарын хамгийн том олон улсын чуулга уулзалт, үзэсгэлэн "Mining week"-д МЭХГУУ ҮЭ-ийн Холбоог оролцуулан хамтарч хийх саналыг МУУҮА-аас гаргалаа.*

***2025.11.17** МЭХГУУ ҮЭ-ийн Холбоо ҮЭХ-ны сонгуульт ажилтнуудын нэгдсэн хуралдаанд оролцон үйл ажиллагааны тухай санал, хүсэлтээр яриа хэлэлцээ өрнүүлэн, манлайлагч тэргүүлэгч гишүүдэд МҮЭ болон салбарын Холбооны нэрэмжит шагнал гардуулан урамшуулав.*

# Салбарын 2026-2027 оны Хамтын хэлэлцээрийн багт ҮЭ-ийн Хорооны төлөөлөл ажиллав.

*Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоо, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци* ***3****-н тал хамтран* ***2026-2027*** *оны "Хамтын хэлэлцээр"-ийг* ***2026-10-01****-с эхлэн* ***2026-10-30****-ны өдөр ГБХНХ-ийн яаманд бүртгүүлэн хэрэгжив.*

*Тус ҮЭ-ийн Хороонд* ***нэн тулгамдсан*** *2 асуудлыг* ***2025-09-01****-ны өдрийн* ***31*** *тоот албан бичгээр МЭХГУУ ҮЭ-ийн Холбоонд шийдвэрлүүлэхээр илгээж, Салбарын хамтын хэлэлцээрийн 6 дугаарт "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар" бүлэгт* ***6.7*** *болон* ***6.11*** *дах заалт болгон тусгаж, аж ахуй нэгж, албан байгууллагуудын заавал хэрэгжүүлэх үүрэг болгон баталгаажуулав.*






ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН
УУЛ, УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОРОО

оны 25 сар 09 өдөр 01
№ 31
Улаанбаатар хот

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ УУЛ
УУРХАЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНД

*Хамтын хэлэлцээрт санал хүргүүлэх тухай*

Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023-2024 оны хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт, биелэлтийн тайлан, үр дүнг хэлэлцэн баталгаажуулсанд, салбарын анхан шатны ҮЭ-ийн Хороодын нэгдсэн уулзалтыг "Багануур"ХК-ийн ҮЭ-ийн Хороо зохион байгуулан, 2025-2026 оны хамтын хэлэлцээрийн зорилго, зорилтоо тодорхойлон, бодит үр дүн гаргах саналуудаа нэгтгэн ажилласанд талархал илэрхийлье.

"Оюу Толгой"ХХК-ийн Уул уурхайн ажилтны үйлдвэрчний Хорооноос гишүүд ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл, үндсэний ажил мэргэжлийн ангилал, хамтын хэлэлцээр дүгнэх тухай дараагийн хэлэлцээрт оруулах шаардлагатай гэж үзэн санал хүргүүлж байна.

Үүнд:

- Олон улсад ажил мэргэжлийн стандарт ангиллын суурь зарчим бүтцийг боловсруулсан байдаг түүнтэй уялдуулан МУ-ын Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (ҮАМАТ)-08-ын дагуу уул уурхайн компаниуд ажилтны мэргэжлийн ангилал, ажлын байрны нэршлийг зөв тодорхойлох, шинэчлэн тогтоох, кодлох, индекс/кодыг дүйцүүлэн хэрэглэх боловсруулахыг байгууллагуудад үүрэг болгон оруулах. МУ-ын хэмжээнд сүүлийн үед ажил, мэргэжлийн агуулга, нэр төрөлд нэлээд өөрчлөлт гарч байгаа бөгөөд уул уурхайн чиглэлд ажлын байрны шинэ нэршил ихээр нэмэгдсэн.
- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний хяналт хэмжилтэд ҮЭ-ийн Хорооны төлөөлөл оруулах, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллагын тайлан, дүгнэлтийг ҮЭ-ийн Хороонд гаргаж өгөх гэж оруулах. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/115 дугаар тушаал "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам"-д ҮЭ-ийн байгууллага буюу ажилтны төлөөлөл оролцох тухай огт дурдаагүй байгаа нь ажил олгогч нарт ашигтай байдлыг бий болгон, хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл хөлсийг өөрсдийн дураар өөрчлөн олгох боломжийг олгож байна.
- 2023-2024 оны Хамтын хэлэлцээрийн биелэлт, дүгнэлтэд уул уурхайн олборлох салбарт нийт ажиллагсдын 26,1 хувь хамрагдсан байгаа нь хангалттүй тоон үзүүлэлт бөгөөд дараагийн хэлэлцээрийн дүгнэлтийг 51,0 хувьд хүргэхээр зорилт тавьж ажиллах. Салбарын Холбооноос хэлэлцээрийн биелэлт, үнэлгээ хийхэд ажлын хэсэг гарган салбарын анхан шатны ҮЭ-ийн Хороонууд, ажил олгогчийн төлөөлөлтэй биечлэн уулзалт хийж, үнэлгээ өгч дүгнэх нь ажил олгогчид ҮЭ-ийн байгууллагын нэр

Хаяг: Улаанбаатар-14240, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Чингисийн өргөн чөлөө-15, 8 дугаар байр,
Парк Виев Резиденс, 3 дугаар давхар, 301 тоот
Утас: +976 9400 0656
И-Мэйл: oyutolgo@ottu.mn



хүндийг өсгөх, анхаарч хүндэтгэн үзэх боломжийг бий болгон цаашид гишүүд, ажилтнуудын ашиг сонирхлыг хамгаалахад илүү сайжруулалт хийгээд явах боломжтой. Иймд дараа жилүүдийн төсөв, төлөвлөгөөнд оруулан ажиллах.

Бидэнд тулгамдаж буй асуудлуудтай танилцан үзэж, дэвшүүлэн хэрэгжүүлэх саналуудыг хүлээн авч дараагийн хэлэлцээрт оруулан, уул уурхайн салбарын гишүүд ажилтнуудын хөдөлмөрлөх эрх нийгмийн баталгааг хангахад үнэтэй хувь нэмэр оруулан хамтран ажиллана хэмээн амжилт хүсэж байна.

ХҮНДЭТГЭСЭН,

''ОЮУ ТОЛГОЙ'' ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН
АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ХОРООНЫ ДАРГА Д.ОЮУНТУНГАЛАГ

# Салбарын 2026-2027 оны Хамтын хэлэлцээрт ОТ ХХК-ийн УУАҮЭ-ийн Хорооноос санаачлан оруулсан 2 заалт

***6.7*** *Монгол Улсын холбогдох хууль, журмын дагуу хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэж, мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайлан дүгнэлтийг ҮЭ-ийн хороонд хүргүүлнэ.*





АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЛБАРЫН 2026-2027 ОНЫ
ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хамтын хэлэлцээр нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа тул 2025 оны 11 сарын 19-ний өдөр бүртгэв.

Улаанбаатар хот
2025 он



6.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг үлгэр жишээ зохион байгуулсан аж ахуйн нэгж байгууллагыг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үндэсний хорооноос олгодог "Эрүүл аюулгүй байдлыг эрхэмлэгч байгууллага"-аар шалгаруулахад талууд дэмжлэг үзүүлнэ.

6.2 Ажил олгогч ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийг бууруулах арга хэмжээг авна.

6.3 Аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны ISO-45001 стандарт, Хариуцлагатай уул уурхайн кодекс, Тогтвортой уул уурхайн төлөө стандартыг хэрэгжүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах, менежментийн тогтолцооны баталгаажуулалт хийлгэх ажлыг талууд хамтран хэрэгжүүлнэ.

6.4 Ажил олгогч нь ажилтнуудыг гэнэтийн осол, эрүүл мэндийн багц даатгалд заавал даатгуулна.

6.5 Жил бүрийн 4 дүгээр сарын 28-нд үйлдвэрлэлийн ослоор амь эрсдсэн хүмүүст хүндэтгэл үзүүлэх өдрийг тохиолдуулан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг салбарын хэмжээнд талууд хамтран зохион байгуулна.

6.6 Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын дэргэдэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд талууд хамтран ажиллах, салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар санал дүгнэлт гаргах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, гарсан осол, гэмтлийн талаарх мэдээллийг солилцох, аж ахуйн нэгжүүдэд мэргэшил арга зүйн зөвлөмж өгч ажиллана.

6.7 Монгол Улсын холбогдох хууль, журмын дагуу хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэж, мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайлан дүгнэлтийг ҮЭ-ийн хороонд хүргүүлнэ.

байгууллагын 176-р конвенц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 155-р конвенцыг хэрэгжүүлэх ажлыг талууд хамтран зохион байгуулж хэрэгжилтэд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Монголын эрчим хүч, геологи уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци хамтран хяналт тавина.

6.9 Аж ахуйн нэгж, байгууллагууд ажилтнуудад зориулсан сэтгэл зүйн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлнэ.

6.10 Уурхайн бүсийн тоосжилт, дуу чимээ, химийн хорт бодисын хэмжээг бууруулах чиглэлээр орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

6.11 Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (ҮАМАТ-08)-ын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын ажил мэргэжлийн ангилал, ажлын байрны нэршлийг зөв тодорхойлох, шинэчлэн тогтоох, индекс/кодыг дүйцүүлэн хэрэглэхийг аж ахуйн нэгж байгууллагууд заавал хэрэгжүүлнэ.

**Долоо. Үйлдвэрчний эвлэлийн эрхийг хангах талаар**

7.1 Ажил олгогч нь Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Монгол Улсын соёрхон баталсан ОУХБ-ын конвенцуудыг хэрэгжүүлнэ. Үүнд нь:

***6.11*** *Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (**ҮАМАТ-08**)-ын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын ажил мэргэжлийн ангилал, ажлын байрны нэршлийг зөв тодорхойлох, шинэчлэн тогтоох, индекс/кодыг дүйцүүлэн хэрэглэхийг аж ахуйн нэгж байгууллагууд заавал хэрэгжүүлнэ.*

# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

*Бичиг хэрэг архив хадгалалт, хамгаалалт, элекрон файл бий болгох*

| | |
|---|---|
| *Албан бичиг, тогтоол, гэрээ* | *Албан бичгүүд, тогтоолууд , гэрээ архив цэгцлэх ажлууд хийгдсэн. Электрон файл хийгдэж байна.* |
| *Явсан ирсэн албан бичгийн бүртгэлийг тогтмолжуулах* | *Албан бичиг бүртгэл цэгцлэсэн хэрэгжүүлсэн.* |
| *Санхүүгийн баримтуудын хуулбар архив (Эх хувь нягтлан бодох бүртгэлд)* | *Санхүүгийн гэрээнд тусгагдаагүй тул "Magic consulting" LLC гэрээний хэрэгжилт дуусахад бүх баримтуудыг хүлээлгэн өгнө.* |
| *Гишүүнчлэлийн цахим үнэмлэх* | *МҮЭ-ийн Холбоо санхүүгийн асуудал шийдээгүй , хүлээгдэж байна.* |

# *АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА*